



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/353

Номгон


Г Газар эзэмших эрхийн гэрчилгээт
дуудлага худалдаа дахин явуулах тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 5.1.2, 10.1.1, 10.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Аймгийн газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөөг дүгнэж, 2021 оны төлөвлөгөө батлах тухай” 116 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын Есөнбулаг 9 дүгээр багийн нутагт 265м² газрыг Худалдаа нийтийн үйлчилгээний зориулалтаар, Рашаант 10 дугаар багийн нутагт 1000 м² газрыг Шатах, тослох материал түгээгүүрийн зориулалтаар, Номгон 1 дүгээр багийн нутаг 500м² газрыг Худалдаа нийтийн үйлчилгээний зориулалтаар, Номгон 1 дүгээр багийн нутаг 265м² газрыг Худалдаа нийтийн үйлчилгээний зориулалтаар тус тус хавсралтад заасны дагуу Газар эзэмших эрхийн гэрчилгээт дуудлага худалдааг зарласугай.

2.Дуудлага худалдааг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010919



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭТ ДУУДЛАГА
ХУДАЛДААГААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН ЖАГСААЛТ

№	Баг	Байршил	Зориулалт	Талбайн хэмжээ /м2/	Анхны үнэ	Дуудлага худалдаа Зохион байгуулагдах он.сар.өдөр
1	Есөнбулаг 9-р баг	Эрх чөлөөний гудамж-4, 414а тоот	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	265м ²	1.987.500	2021.06.21
2	Рашаант 10-р баг	Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-6, 607а тоот	Шатах, тослох материал түгээгүүрийн газар, агуулах	1000 м ²	7.500.000	2021.06.21
3	Номгон 1-р баг	Тээвэрчдийн гудамж-3, 315 а тоот	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	500 м2	1.497.000	2021.06.21
4	Номгон 1-р баг	Тээвэрчдийн гудамж-3, 301 а тоот	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	265 м2	795.000	2021.06.21